

МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ СОНИРХОГЧИЙН РАДИО СТАНЦАД ДОЛГИОН АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Радио долгионы тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт радио долгионыг зүй зохистой ашиглах, радио сонирхогчидод давтамж ашиглах эрхийн бичиг олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

1.2.1. Радио сонирхогч – Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч, аливаа нэгэн бизнес, улс төрийн ашиг сонирхол агуулахгүйгээр зөвхөн өөрийн техникийн сонирхолыг хөгжүүлэх зорилгоор радио станц ашиглагч хүнийг хэлнэ.

1.2.2 Радио сонирхогчидын төв байгууллага-Радио сонирхогчидын байгууллагуудаас төлөөлөлтэй олон улсын ижил төрлийн байгууллагад Монгол Улсын радио сонирхогчдыг төлөөлөх эрх бүхий төрийн бус байгууллага.

1.3. Радио сонирхогчид нь Монгол Улсын Үндэсний Радио давтамж хуваарилалтын төлөвлөлтөнд радио сонирхогчийн албанд зориулан хуваарилсан давтамжийн зурваст ажиллана.

1.4. Радио сонирхогчидын төв байгууллагууд нь Харилцаа холбооны зохицуулах хорооны /цаашид “ХХЗХ” гэх/-ноос зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллага байна. Радио сонирхогчидын байгууллага нь радио сонирхогчдод эрх олгох, сургалт явуулах болон тэдгээрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

1.4.1. Радио сонирхогчидын төв байгууллага нь өөрсдийн үйл ажиллагааны тухай тайлан мэдээг жил бүрийн эцэст ХХЗХ-нд гаргаж өгнө.

1.4.2. Радио сонирхогчидын байгууллагууд нь ХХЗХ-ны 2003 оны 11 дүгээр сарын 17-ны 36-р тогтоолоор батлагдсан Радио давтамж ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээний дагуу төлбөр төлнө.

1.5. Радио сонирхогчдын төв байгууллага нь олон улсын ижил төрлийн байгууллагад Монгол Улсын радио сонирхогчдын байгууллагуудыг төлөөлж болно.

Хоёр. Зөвшөөрөл олгох

2.1. Сонирхогчийн радио станц ашиглах зөвшөөрлийг тус улсын харъяат болон радио сонирхогчийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн аль нэг улсын харъяат, зохих мэргэжлийн шалгалт өгсөн иргэдэд олгоно. А ангилалын эрхийн бичгийг 14 нас, В ангилалын эрхийн бичгийг 12 нас хүрсэн иргэдэд олгоно.

2.2. Радио сонирхогчдын мэргэжлийн шалгалт авах бүрэлдхүүн нь ХХЗХ, радио сонирхогчдын байгууллагаас төлөөлөлтэй байна.

2.3. Сонирхогчийн радио станц ажиллуулах зөвшөөрөл хүсэгч нь доорхи бичиг баримтыг бүрдүүлэн эрх бүхий радио сонирхогчидын байгууллагад өгнө. Үүнд:

- Иргэний үнэмлэх /төрсний гэрчилгээ/-ний хуулбар
- Хоёр хувь өргөдөл (өргөдлийн маягтыг **х**-д үзүүлэв)
- Зохих мэргэжлийн шалгалт өгсөн баримт бичиг
- Ашиглах гэж буй радио станцын техникийн үзүүлэлтүүд

2.4. Өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Радио сонирхогчийн байгууллага нь хүсэлт гаргагчийн тоног төхөөрөмжинд шалгалт хийж, техникийн үзлэгийн акт гаргана. (Техникийн үзлэгийн актыг **х**-т үзүүлэв)

2.5. Монгол Улсын нутаг дэвсгэрээс ажиллах сонирхогчийн радио станцын зөвшөөрлийг техникийн актыг үндэслэн эрх бүхий радио сонирхогчидын байгууллагаас 7 хоногийн дотор олгоно.

2.6. Сонирхогчийн радио станц ашиглах зөвшөөрөл нь үндсэн (5 жилийн хугацаанд) ба түр (6 хүртэлх сарын хугацаанд) гэсэн хоёр төрөл байна. (Зөвшөөрлийн маягтыг **х**-д үзүүлэв)

2.7. Монгол Улсын иргэдэд техникийн мэдлэг, ур чадвар, дадлага туршлага зэргээс шалтгаалан А, В ангиллын эрхийн бичгийг олгоно.

2.8. Сонирхогчийн радио станц ашиглах зөвшөөрөл эзэмшигч нь ХХЗХ-гоор хянуулж батлуулсан төлбөрийг радио сонирхогчийн байгууллагад төлнө.

Гурав. Гадаадын иргэдэд зөвшөөрөл олгох

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт сонирхогчийн радио станц ажиллуулах сонирхол бүхий гадаадын иргэд нь өөрийн улсын зөвшөөрөлгүй бол ХХЗХ-нд бүртгүүлэн 2-р бүлэгт заасны дагуу зөвшөөрөл авна.

3.2. Гадаадын радио сонирхогч нь өөрийн улсын зөвшөөрөлтэй бол радио станцыг ашиглахаас 14 хоногийн өмнө дор дурдсан бичиг баримтуудыг бүрдүүлэн ХХЗХ-нд өгнө. Үүнд:

- Паспортын хуулбар
- Өөрийн улсаас олгосон сонирхогчийн радио станц ажиллуулах зөвшөөрлийн хуулбар
- Зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл (өргөдлийн маягтыг **х**-д үзүүлэв)
- Ашиглах гэж буй радио станцын техникийн үзүүлэлтүүд

3.3. Гадаад орны сонирхогч нь радио станцаа ажиллуулахдаа Монгол Улсын радио сонирхогчидын мөрдөн ажиллаж буй давтамжийн зурваст ажиллана.

3.4. ХХЗХорооны 2003 оны 36-р тогтоолоор батлагдсан Радио давтамж ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээний дагуу төлбөр төлнө.

Дөрөв. Сонирхогчийн радио станц ажиллуулах зөвшөөрлийн сунгалт

4.1. Сонирхогчийн радио станц ажиллуулах зөвшөөрөлийг сунгуулахдаа хугацаа дуусахаас нь 14 хоногийн өмнө дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн Радио сонирхогчийн байгууллагад өгнө. Үүнд:

- Хугацаа сунгуулах тухай өргөдөл
- Өмнө олгосон зөвшөөрлийн хуулбар
- Дараа жилийн зөвшөөрлийн төлбөр хийсэн баримт

4.2. Зөвшөөрлийн хугацаагаа сунгуулахаар хүсэлт гаргасан этгээд нь Харилцаа холбооны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг зөрчөөгүй гэж үзвэл хугацаа сунгуулах баримт бичгийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор радио сонирхогчийн байгууллага сунгана.

Тав. Сонирхогчийн радиостанцын ангилал, төрөл, дуудлага

5.1. Сонирхогчийн радио станцыг давтамжийн зурвас, ажлын горим, нэвтрүүлэгчийн чадал зэрэг үзүүлэлтээр нь А, В гэж 2 ангилна. (X5)

5.2. Сонирхогчийн радио станцыг зориулалтаар нь:

- Хувийн станц
- Хамтын станц
- Дахин дамжуулагч станц
- Чиглүүлэгч станц гэж 4 төрөлд хуваана.

5.3. Сонирхогчийн радио станцад олон улсын хуваарийн дагуу дуудлагын үндсэн хуваарилалтыг ХХЗХ-ноос, дэд хуваарилалтыг радио сонирхогчдын төв байгууллага хийнэ.

Зургаа. Ашиглах төхөөрөмжүүд

6.1. Сонирхогчийн радио станц нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- Нэвтрүүлэгч
- Хүлээн авагч
- чадлын өсгөгч
- антенны байгууламж
- бусад зүйл (компьютер, антенны тюнер, модем, түлхүүр гэх мэт)

6.2. Радио сонирхогчид нь тусгай зориулалтын дохио боловсруулах эцсийн төхөөрөмжүүдийг ашиглахыг хориглоно.

6.3. Сонирхогчидын радиостанц нь аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, газардуулга хийсэн байх ба антенны байгууламж нь орчиндоо аюулгүй байхаар бэхлэгдсэн байна.

Долоо. Холбоо тогтоох

7.1. Сонирхогчийн радиостанцаар зөвхөн сонирхогчийн станцуудтай шууд буюу эсвэл дахин дамжуулагч, сонирхогчийн хиймэл дагуул, сар ашиглаж холбоо тогтоохыг зөвшөөрнө.

7.2. Радио сонирхогчид нь холбоо барихдаа эхэнд нь, төгсгөлд нь харилцагчийн болон өөрийн дуудлагыг зохих журмын дагуу нэвтрүүлэх бөгөөд хэрэв удаан хугацаагаар холбоо барьж байгаа тохиолдолд 10 минут тутамд нэвтрүүлнэ.

7.3. Радио сонирхогчийн холбоонд албан ёсны энгийн болон Q код хэрэглэх бөгөөд ямар нэгэн шифр, далд утга бүхий хэллэг ашиглахыг хориглоно.

7.4. Радио сонирхогч нь аюулын дохио SOS (телеграфаар) ба MAYDAY (телефоноор) хүлээн авсан тохиолдолд зохих газарт яаралтай мэдэгдэнэ. Радио сонирхогчид нь холбогдох эрх бүхий хүмүүст зөвхөн онцгой тохиолдолд /байгалийн гамшиг, гоц халдварт өвчин зэрэг / радио станцаа хэрэглүүлэх үүрэгтэй.

Найм. Станцын бичиг баримт

8.1. Сонирхогчийн радио станцын бичиг баримтад эрхийн бичиг, техникийн үзлэгийн акт, аппаратын журнал, электрон журнал, QSL карт орно.

8.2. Аппаратын журналд доорхи зүйлүүд бичигдэнэ. Үүнд:

- Холбоо барьсан он, сар, өдөр
- Холбоо барьсан давтамж
- Горим
- Гаралтын чадал
- Холбоо барьж эхэлсэн, дууссан цаг
- Харилцагч станцын дуудлага
- QSL карт явуулсан ба хүлээн авсан тухай тэмдэглэл
- Бусад мэдээлэл (харилцагчийн оршин сууж буй газар, нэр г.м.)

8.3. Радио сонирхогч нь холбоо барьсан харилцагч бүрдээ QSL карт илгээж баталгаажуулах үүрэгтэй.

Ес. Хяналт шалгалт

9.1. Харилцаа холбооны улсын байцаагчид, ХХЗХорооны холбогдох мэргэжилтэн сонирхогчидын бүх төрлийн радио станц, нэвтрүүлэгч төхөөрөмжүүдийн ашиглалтанд Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийнэ.

9.2. Сонирхогчийн радио станц ашиглагч нь улсын байцаагчид болон ХХЗХорооны мэргэжилтэнгүүдийг хяналт шалгалт хийх үед тавьсан шаардлагыг биелүүлнэ.

9.3 Шаардлагатай тохиолдолд радио сонирхогчидын хоорондоо холбоо тогтоох явцыг Радио долгионы хяналтын станцаас хянаж шалгана.

9.4 Радио сонирхогчид нь өөрсдийн зурваст ажиллаж буй сонирхогч биш радио давтамж ашиглагч этгээдийг үйл ажиллагаагаа зогсоохыг шаардах энэ зөрчлийн талаархи мэдээллийг холбогдох байгууллагуудад танилцуулж болно.

Арав. Хариуцлага

10.1. Радио сонирхогч нь өөрт олгогдоогүй давтамжийн хуваарь, горим, чадал, техникийн шаардлага хангаагүй нэвтрүүлэгч, антенн болон бусад тоног төхөөрөмж хэрэглэсэн мөн сонирхогчийн бус зориулалтаар ашигласан, бусдад радио долгионы шуугиан үүсгэж, нөлөөлөл учруулсан тохиолдолд Монгол Улсын харилцаа холбооны тухай хууль, Монгол Улсын Радио долгионы тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

----- о О о -----